





ҮНДЭСНИЙ  
СТАТИСТИКИЙН  
ХОРОО

# БОЭЗДС-УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНС 2021

2022 он

## АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт .....	3
Зургийн жагсаалт.....	3
Товчилсон үгийн жагсаалт .....	3
НЭГ. БОЭЗДС-ЕРӨНХИЙ ХҮРЭЭ БА УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ АРГА ЗҮЙ .....	6
1.1. БОЭЗДС-ЕРӨНХИЙ ХҮРЭЭН ДЭХ БИЕТ УРСГАЛЫН ДАНС.....	6
1.2. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ АРГА ЗҮЙ .....	7
ХОЁР. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ ГҮЙЦЭТГЭЛ.....	9
2.1. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ ҮНДСЭН ҮР ДҮН.....	9
2.2. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНААС ГАРАХ ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	14
ДҮГНЭЛТ.....	16
ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ .....	16
ХАВСРАЛТ.....	17
АШИГЛАСАН МАТЕРИАЛ .....	25

## Хүснэгтийн жагсаалт

ХҮСНЭГТ 1. УСНЫ БНАХ, 2021 он	9
ХҮСНЭГТ 2. УСНЫ БНАХ-ийн нэгтгэл, 2019-2021 он, сая м <sup>3</sup>	9
ХҮСНЭГТ 3. УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, салбараар, усны нөөцийн төрлөөр, 2021 он	10
ХҮСНЭГТ 4. УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, зориулалтаар	11
ХҮСНЭГТ 5. УСНЫ НИЙТ АШИГЛАЛТ, салбараар, 2021 он	11
ХҮСНЭГТ 6. УСНЫ НИЙТ АШИГЛАЛТ, салбараар	12
ХҮСНЭГТ 7. УСНЫ НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ, салбараар, 2021 он	12
ХҮСНЭГТ 8. УСНЫ НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ, салбараар	13
ХҮСНЭГТ 9. УСНЫ НИЙТ ХЭРЭГЛЭЭ, салбараар	13
ХҮСНЭГТ 10. ТХЗ 6.3.1-ИЙГ ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	14
ХҮСНЭГТ 11. ТХЗ 6.4.1-ИЙГ ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2019-2021 оноор	15
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 1. УСНЫ БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ, 2021 он, сая м <sup>3</sup>	17
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 2. УСНЫ БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ НӨӨЦИЙН ХҮСНЭГТ, 2021 он, сая м <sup>3</sup>	18
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 3. УСНЫ БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ, 2020 он, сая м <sup>3</sup>	19
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 4. УСНЫ БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ НӨӨЦИЙН ХҮСНЭГТ, 2020 он, сая м <sup>3</sup>	20
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 5. УСНЫ БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ, 2019 он, сая м <sup>3</sup>	21
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 6. УСНЫ БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ НӨӨЦИЙН ХҮСНЭГТ, 2019 он, сая м <sup>3</sup>	22
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 7. БАЙГАЛИЙН УСНЫ НӨӨЦИЙН ОРЦЫН АНГИЛАЛ	23
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 8. УСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АНГИЛАЛ	23
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 9. ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ УСНЫ ҮЛДЭГДЛИЙН АНГИЛАЛ	23
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 10. ЭДИЙН ЗАСГААС БАЙГАЛЬ ОРЧИН УРУУ УРССАН УСНЫ ҮЛДЭГДЛИЙН АНГИЛАЛ	24
ХАВСРАЛТ ХҮСНЭГТ 11. ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ УСТАЙ ХОЛБООТОЙ ГОЛЛОХ ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН АНГИЛАЛ	24

## Зургийн жагсаалт

ЗУРАГ 1 . БОЭЗДС-ИЙН ХҮРЭЭНИЙ ДАНСУУДЫН ХЭЛБЭР, ТӨРӨЛ	5
ЗУРАГ 2 . БОЭЗДС-ИЙН УСНЫ ДАНСНЫ ХАМРАХ ХҮРЭЭ	6
ЗУРАГ 3 . УСНЫ БИЕТ УРСАЦ	7
ЗУРАГ 4 . ЭДИЙН ЗАСАГ ДОТОРХ УСНЫ БИЕТ УРСАЦ	7
ЗУРАГ 5 . УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, эх үүсвэрээр, сая м <sup>3</sup>	10
ЗУРАГ 6 . УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, дүнд эзлэх хувь, ашиглалтын төрлөөр	11
ЗУРАГ 7 . УСНЫ НИЙТ БУЦАЛТ, усны ашигласан зориулалтаар, дүнд эзлэх хувь	13
ЗУРАГ 8. УСНЫ ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭ, нийт ашиглалтын дүнд эзлэх хувь, салбараар, 2021 он	14

## Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БНАХ	Биет хэмжээгээр илэрхийлсэн Нөөц, Ашиглалтын хүснэгт
БНА	Бүтээгдэхүүний нэгдсэн ангилал
БОЭЗДС	Байгаль орчин-эдийн засгийн дансны систем
ГНС	Газрын нэгдмэл сангийн тайлан
НАХ	Нөөц, ашиглалтын хүснэгт
НӨ	Нэмэгдэл өртөг
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБСХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Статистикийн Хэлтэс
ОУВС	Олон Улсын Валютын Сан
УЦС	Усан цахилгаан станц
ҮСХ	Үндэстний Статистикийн Хороо
ҮТС	Үндэстний тооцооны систем
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХХААБ	Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага
ЭЗҮАСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага

#### ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

Ц.Сэлэнгэ      БХАГ-ын ҮТХ-ийн статистикч  
И-мэйл            [selenge\\_ts@nso.mn](mailto:selenge_ts@nso.mn)  
Утас:                51-261502

#### ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Б.Саранчимэг    БХАГ-ын дарга  
Б.Баярмаа        БХАГ-ын ҮТХ-ийн дарга

#### ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу-44  
Засгийн газрын III байр  
Утас:                1900-1212  
Факс:                (976-11)-324518  
Цахим хуудас :    <http://www.nso.mn>, [www.1212.mn](http://www.1212.mn)  
И-мэйл:             [information@nso.mn](mailto:information@nso.mn)

## ОРШИЛ

ҮСХ нь дэлхийн улс орнуудын статистикийн байгууллагуудын нэгэн адил НҮБ-ын Статистикийн Комиссын 43-р чуулганаар батлагдсан улс орны байгаль орчин, эдийн засаг хоорондын харилцан холбоог илэрхийлж, байгалийн нөөц, түүний өөрчлөлтийг тодорхойлох олон зорилтыг агуулсан олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичиг болох “Байгаль орчин-эдийн засгийн дансны систем”-ийг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

“Байгаль орчин-эдийн засгийн дансны систем”-ийг НҮБ, Европын холбоо, НҮБ-ын ХХААБ, ОУВС, ЭЗХАХБ, Дэлхийн банк хамтран гаргасан бөгөөд улс орнуудыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгосон. Улс орнууд БОЭЗДС-ийн хүрээний дэд дансуудыг байнгын давтамжтай байгуулах асуудлыг албан ёсны статистикийн хөтөлбөрийн нэг хэсэг болгож байна.

БОЭЗДС-ийн хүрээний дэд данснуудын мэдээлэлд үндэслэн Тогтвортой хөгжлийн зорилго болон ногоон хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцох боломж бий болохоос гадна байгаль орчин, эдийн засгийн талаар бодлого боловсруулж, хэрэгжилтийг үнэлэх үндсэн суурь мэдээлэл болох юм.

БОЭЗДС-ийн хүрээний дэд данснуудын биет урсгалын данс, мөнгөн урсгалын данс, хөрөнгийн данс гэсэн үндсэн гурван хэлбэрт авч үзэх бөгөөд эдгээр нь дотроо дэд дансуудад хуваагдана. (Зураг 1).

ЗУРАГ 1 . БОЭЗДС-ИЙН ХҮРЭЭНИЙ ДАНСУУДЫН ХЭЛБЭР, ТӨРӨЛ



ҮСХ нь “Материалын урсгалын данс байгуулах аргачлал”, “Байгаль орчныг хамгаалах зардлын данс байгуулах аргачлал”, “Эрчим хүчний биет урсгалын данс байгуулах аргачлал” “Байгаль орчны татварын данс”, “Агаар дахь ялгаруулалтын данс байгуулах аргачлал”, “Усны биет урсгалын данс байгуулах аргачлал”, “Хатуу хог хаягдлын данс байгуулах аргачлал”, “Усны нөөцийн хөрөнгийн данс байгуулах аргачлал”-ыг боловсруулж, данснуудыг байгуулж тархаасан.

Тайлант онд “Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын данс байгуулах аргачлал”-ыг боловсруулахаар ажиллаж байна.

БОЭЗДС-ийн хүрээний дэд данснуудыг байгуулахад үндэсний тооцоо, гадаад худалдааны статистик, Засгийн газрын санхүүгийн статистик, бизнесийн статистик, ӨНЭЗС-ны мэдээлэл, байгаль орчинтой холбогдох статистикийн үзүүлэлтүүд: хүлэмжийн хийн тооллого, эрчмийн, усны, хог хаягдлын, газар, ойн статистик зэргийг ашиглана.

## НЭГ. БОЭЗДС-ЕРӨНХИЙ ХҮРЭЭ БА УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ АРГА ЗҮЙ

### 1.1. БОЭЗДС-ЕРӨНХИЙ ХҮРЭЭН ДЭХ БИЕТ УРСГАЛЫН ДАНС

БОЭЗДС-Усны дансны систем нь усны нөөц, хүрээлэн буй орчноос болон эдийн засаг дахь усны урсацын биет болон мөнгөн дүнгээрх мэдээлэл болон усны чанарын асуудлыг хамардаг. (Зураг2)

Одоогоор манай улс өмнө дурдсанчлан устай холбоотой “Усны биет урсгалын данс байгуулах аргачлал”, “Усны нөөцийн хөрөнгийн данс байгуулах аргачлал”-ыг боловсруулаад байна.

ЗУРАГ 2 . БОЭЗДС-ИЙН УСНЫ ДАНСНЫ ХАМРАХ ХҮРЭЭ



**Хөрөнгийн данс:** Тайлант хугацааны эхэн ба эцэс дэх усны нөөцийн үлдэгдэл болон тухайн хугацаанд гарсан нөөцийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг агуулна. Усны нөөцийн хөрөнгийн данс, усны чанарын данс, үйлдвэрлэсэн хөрөнгийн данс гэсэн 3 төрлийн хөрөнгийн дансад хуваагдана.


**Урсгал данс:** Эдийн засагт оруулж буй усны хувь нэмэр, эдийн засгаас байгаль орчинд үзүүлж буй дарамт (усны олборлолт, усан дахь ялгаруулалт) зэргийн талаарх мэдээллийг өгдөг. Эдгээр данс нь биет хэмжээгээр илэрхийлэгдэх бөгөөд үндэсний тооцооны данстай шууд холбогддог тул эдийн засагч, төлөвлөгч нарт усны асуудлыг ойлгоход хялбар болгодог. Дансууд нь үйлдвэр, айл өрхүүдийн усны олборлолт, ашиглалт, усны буцалт зэрэг эдийн засаг ба байгаль орчин хоорондын усны урсацыг биет хэмжээгээрх нөөц, ашиглалтын хүснэгтийн хэлбэрээр харуулдаг.

**Гибрид ба эдийн засгийн данс:** Эдгээр нь бүтээгдэхүүнтэй холбоотой усны нөөц, ашиглалтыг мөнгөн хэлбэрээр харуулдаг ба дараах байдлаар тодорхойлно, үүнд: а. Бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой зардал (үйл ажиллагааны), б. Үйлдвэрлэлээс олсон орлого, в. Усны дэд бүтэц дэх хөрөнгө оруулалт, г. Засвар үйлчилгээний зардал, д. Ус ашиглагчдын төлбөр буюу усны тариф, мөн усны татаасын түвшин. Гибрид данс нь биет болон мөнгөн хэлбэрийн аль алиныг нь нэг дансад нэгтгэдэг бол эдийн засгийн дансууд нь дээр дурдсан мэдээллээр гибрид дансыг өргөжүүлдэг.

Усны биет урсгалын данс нь БОЭЗДС-ийн хүрээний биет урсгалын данс буюу биет хэмжээгээр илэрхийлсэн нөөц, ашиглалтын хүснэгтийн нэг бүрэлдэхүүн юм. Усны биет урсгалын дансны зорилго нь байгалиас авч ашиглах усны нөөц, эдийн засаг доторх усны ашиглалт, байгальд хаяж буй усны урсацыг эдийн засгийн салбараар тооцож, бодлого боловсруулалтад ашиглах мэдээллийн системийг бий болгоход оршино.

Усны биет урсац нь байгаль орчноос эдийн засагт хэрэглэгдсэн усны нөөцөөс эхлэн эдийн засаг доторх аж ахуйн нэгж, өрхийн нийлүүлсэн болон хэрэглэсэн усны урсац, түүнчлэн байгаль уруу буцаад урсаж байгаа усны урсацыг биет хэмжээгээр тодорхойлно (Зураг 3).

### ЗУРАГ 3 . УСНЫ БИЕТ УРСАЦ




Эх үүсвэр: "Байгаль орчин, эдийн засгийн дансны систем-Ус"-ны арга зүйн хүрээ

Усны биет урсгалын данс нь БОЭЗДС-ийн бусад биет урсгалын данс болох усан дахь ялгаруулалтын данс, усны нөөцийн хөрөнгийн данстай холбогдоно. Мөн Усны газраас байгуулсан "Ус ашиглалтын баланс"-ын үр дүнтэй уялдана. Усны биет урсгалын хамрах хүрээнд байгалиас (усны нөөцийн систем) ААНБ, өрхийн өөрийн хэрэглээнд эсвэл түгээх зориулалтаар олборлосон гадаргын ус, газрын доорх ус, хөрсний ус, хурын ус, эдийн засгийн нэгж хооронд болон гадаад эдийн засаг (экспорт, импорт)-тай солилцсон ус буюу уур, халуун ус, ундны болон ундны бус ус, мөн эдийн засгийн нэгжүүдийн үйл ажиллагааны явцад бий болсон цэвэршүүлсэн, цэвэршүүлээгүй хаягдал ус, ууршилт, усны алдагдлыг хамруулна. Байгаль орчин доторх усны урсгалыг усны хөрөнгийн нөөцийн дансанд авч үзнэ.

#### 1.2. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ АРГА ЗҮЙ

Усны биет хэмжээгээр илэрхийлсэн нөөц ашиглалтын хүснэгт нь эдийн засгийн нэгжүүдийн эдийн засгийн нутаг дэвсгэр доторх усны нөөцийн системээс авч хэрэглэсэн ус; эдийн засаг доторх урсгал буюу эдийн засгийн нэгжүүдэд түгээсэн ус болон эдийн засгийн нутаг дэвсгэр доторх усны нөөцийн систем уруу буцаад урсаж байгаа усны урсацыг нөөц, ашиглалтын 2 үндсэн хүснэгтэд нэгтгэн харуулахыг хэлнэ.

### ЗУРАГ 4 . ЭДИЙН ЗАСАГ ДОТОРХ УСНЫ БИЕТ УРСАЦ



Эх үүсвэр: "Байгаль орчин, эдийн засгийн дансны систем-Ус"-ны арга зүйн хүрээ



## Ойлголт тодорхойлолт

Эдийн засгийн нутаг дэвсгэр доторх усны нөөцийн систем нь тухайн нутаг дэвсгэр дэх гадаргын (гол, нуур, хиймэл цөөрөм, цас, мөс, мөсөн гол) болон газрын доорх уснаас бүрдэнэ.

Усны биет урсац нь байгаль орчноос эдийн засагт хэрэглэгдсэн усны нөөцөөс эхлэн эдийн засаг доторх аж ахуйн нэгж, өрхийн нийлүүлсэн болон хэрэглэсэн усны урсгал, түүнчлэн байгаль уруу буцаад урсаж байгаа усны урсгалыг биет хэмжээгээр тодорхойлно

Ус ашиглалтын баланс Тухайн жилд ашиглах боломжит усны нөөцөөс авч ашиглаж байгаа усны хэмжээг хүн амын унд ахуй; хөдөө аж ахуй – мал аж ахуй, газар тариалан; усны эрчим хүч; үйлдвэрлэл; уул уурхай, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэл; амралт сувилал, аялал жуулчлал; ногоон байгууламж зэрэг эдийн засгийн салбараар тооцож гаргасан хүснэгт юм.

Бохир ус зайлуулалт Хэрэглэгчээс гарсан бохир усыг цуглуулан зайлуулах, цэвэрлэх байгууламжид хүргэх үйл ажиллагааг ойлгоно.

Ундны ус Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба хүн амын унд-ахуйн усны чанарын шаардлага хангасан ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байгалийн болон цэвэрлэгээний дараах усыг ойлгоно.

Бохир ус Ус хангамжийн бүхий л эх үүсвэр (ундны, технологийн, хэрэгцээний халуун ус хангамж, дулаан хангамжийн байгууллагын)-ээс хэрэглэгчийн (ахуйн бохир ус) аж ахуйн үйл ажиллагааны үр дүнд бохирдсон ус юм.

Төвлөрсөн ус хангамжийн систем Ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх зориулалт бүхий сүлжээ, барилга байгууламжийг ашиглан стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагааг ойлгоно.

Ариутгах татуургын систем Хэрэглээнээс гарсан бохир ус болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий сүлжээ, барилга байгууламжийг ойлгоно.

## Дансны үндсэн үзүүлэлтүүд

- Усны нийт орц нь байгалиас авсан болон импортоор оруулсан усны хэмжээг илэрхийлнэ. Энэ нь эдийн засаг дахь усны нийлүүлэлтээр дамжуулан тухайн орны байгаль орчин (эсвэл өөр орны байгаль орчин)-д учруулж байгаа нөлөөллийн үзүүлэлт болно.
- Усны дотоодын цэвэр хэрэглээ гэсэн үзүүлэлт нь эдийн засгийн харьяат нэгжүүдийн хэрэглэсэн усны хэмжээ юм. Үүнийг байгаль орчин уруу буцсан усны урсгал болон усны ууршилт, ширгэлт болон бүтээгдэхүүнд шингэсэн усны нийлбэрээр шууд тодорхойлж болно. Энэ үзүүлэлтэд эдийн засгийн нэгж хоорондын усны урсгал болон усны экспортыг хамруулахгүй.
- Усны эцсийн хэрэглээ нь усны ууршилт, ширгэлт болон бүтээгдэхүүнд шингэсэн усны нийлбэртэй тэнцүү бөгөөд цаашид ашиглагдах боломжгүй усны хэмжээг илэрхийлнэ.

Дансад шаардлагатай байгалийн усны нөөцийн орцын ангилал, усны бүтээгдэхүүний ангилал, эдийн засаг дахь усны үлдэгдлийн ангилал, эдийн засгаас байгалт орчин уруу урссан усны үлдэгдлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал зэрэг ангиллын нэршил, тодорхойлолтыг хавсралт хүснэгтээр танилцуулгад оруулсан болно.

## Мэдээллийн эх үүсвэр

- Усны газраас гаргадаг “Ус ашиглалтын жилийн баланс”
- Тухайн жилд Монгол Улсын орон сууц, нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдийн түгээсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээ
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тухайн жилд цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр ногдуулсан мэдээ
- БОАЖЯ-ны захиргааны мэдээ “Усны ашиглалтын жилийн мэдээ (З-БОХ-2.2)”
- Барилга, хот байгуулалтын яамны захиргааны мэдээ “Нийтийн аж ахуйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны 20 ... оны эхний хагас жил / жилийн эцсийн мэдээ (З-НАА-1)”
- ГЕГ-ын барааны экспорт, импортын жилийн мэдээ
- Эрчим хүчний зохицуулах зөвлөл (УЦС-д хэрэглэсэн усны хэмжээ, м<sup>3</sup>)

## ХОЁР. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНЫ ҮНДСЭН ҮР ДҮН

Усны биет хэмжээгээр илэрхийлсэн нөөц, ашиглалтын хүснэгт (БНАХ)-ийн дээд хэсэгт ашиглалтын хүснэгт байх бөгөөд өөрийн хэрэгцээнд болон түгээх, хуваарилах зориулалтаар олборлосон ус, түүний эх үүсвэр (1)-ийг, мөн бусад нэгжээс хүлээн авсан усны ашиглалт (2)-ыг харуулна. Харин хүснэгтийн доод хэсэгт байх нөөцийн хүснэгт нь эдийн засаг доторх усны нөөц (4) болон байгаль орчин уруу буцах усны нийлүүлэлт (5)-ийг харуулна. Усны хэрэглээ (7) нь нийт ашиглалт (3) болон нийт нөөц (6)-ийн зөрүү юм.

#### ХҮСНЭГТ 1. УСНЫ БНАХ, 2021 он, сая м<sup>3</sup>

		Салбарууд				Өрх	Гадаад эдийн засаг	Нийт
		ХАА	Үйлдвэрлэл	Үйлчилгээ	Нийт			
<b>А. БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ</b>								
Байгалиас эдийн засаг уруу	1.Усны нийт олборлолт	339.1	858.0	84.1	1 281.1	11.2		1 292.4
	а Өөрийн хэрэгцээнд	339.1	858.0	6.9	1 203.9	11.2		1 215.1
	б Түгээсэн	-	-	77.2	77.2	-		77.2
Эдийн засаг доторх	2.Эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан усны ашиглалт	0.0	6.7	66.2	72.9	60.3	-	133.2
	а Дахин ашигласан ус	-	-	-	-	-	-	-
	б Хаягдал ус	-	-	56.0	56.0	-	-	56.0
	с Түгээсэн ус	0.0	6.7	10.2	16.9	60.3	-	77.2
<b>3. Усны нийт ашиглалт (1+2)</b>		<b>339.1</b>	<b>864.7</b>	<b>150.3</b>	<b>1 354.1</b>	<b>71.5</b>	<b>-</b>	<b>1 425.6</b>
<b>Б. БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ НӨӨЦИЙН ХҮСНЭГТ</b>								
Эдийн засаг доторх	4. Эдийн засгийн бусад нэгжид нийлүүлсэн ус	0.0	2.6	83.3	85.9	47.3	-	133.2
	а Дахин ашигласан ус	-	-	-	-	-	-	-
	б Хаягдал ус	0.0	2.6	6.1	8.7	47.3	-	56.0
	с Түгээсэн ус	-	-	77.2	77.2	-	-	77.2
Байгаль орчин уруу буцах	5. Нийт буцалт	3.1	766.6	60.1	829.7	8.2		838.0
	а Усны нөөц уруу	3.1	766.6	60.1	829.7	8.2		838.0
	- Гадаргын ус	3.1	766.6	60.1	829.7	8.2		838.0
	- Газрын доорх ус	-	-	-	-	-		-
	- Хөрсний ус	-	-	-	-	-		-
	б Бусад нөөц уруу	-	-	-	-	-		-
<b>6. Усны нийт нөөц (4+5)</b>		<b>3.1</b>	<b>769.2</b>	<b>143.4</b>	<b>915.7</b>	<b>55.5</b>	<b>-</b>	<b>971.2</b>
<b>7. Усны хэрэглээ (3-6)</b>		<b>336.0</b>	<b>95.6</b>	<b>6.8</b>	<b>438.4</b>	<b>16.0</b>	<b>-</b>	<b>454.4</b>

Тайлбар: Саарал нүднүүд нь тодорхойлолтын дагуу хоосон утгатай

Усны БНАХ-ийн 2019-2021 оны үр дүнг нийт дүнгээр нэгтгэн авч үзвэл жилдээ дунджаар 1283.4 сая м<sup>3</sup> ус байгаль орчноос эдийн засагт олборлож, эдийн засгаас байгаль орчин уруу дунджаар 831.4 сая м<sup>3</sup> усыг буцаан нийлүүлж байна.

#### ХҮСНЭГТ 2. УСНЫ БНАХ-ИЙН НЭГТГЭЛ, 2019-2021 он, сая м<sup>3</sup>


Усны урсац	Үзүүлэлт	2019	2020	2021
Байгаль орчноос эдийн засаг уруу	Усны нийт олборлолт	1 368.5	1 281.7	1 292.4
Эдийн засаг дотор	Эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан ус	128.8	129.3	133.2
	<b>Усны нийт ашиглалт</b>	<b>1 497.2</b>	<b>1 411.0</b>	<b>1 425.6</b>
Эдийн засаг дотор	Эдийн засгийн бусад нэгжид нийлүүлсэн ус	128.8	129.3	133.2
Эдийн засгаас байгаль орчин уруу	Усны нийт буцалт	824.7	834.6	838.0
	<b>Усны нийт нөөц</b>	<b>1045.9</b>	<b>963.9</b>	<b>971.2</b>
	<b>Усны хэрэглээ</b>	<b>451.3</b>	<b>447.1</b>	<b>454.4</b>

## 2.1.1. БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ АШИГЛАЛТЫН ХҮСНЭГТ

### УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ

Улсын хэмжээнд 2021 онд нийт 1292.4 сая м<sup>3</sup> ус олборлосны 929.7 (71.9%) сая м<sup>3</sup> усыг гадаргын уснаас, 362.7 (28.1%) сая м<sup>3</sup> усыг газрын доорх усны нөөцөөс олборлосон байна. Усны нийт олборлолт нь 2020 оноос 10.6 (0.8%) сая м<sup>3</sup> өсөж, харин 2019 оноос 76.1 (5.6%) сая м<sup>3</sup>-ээр буурчээ.

ЗУРАГ 5. УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, эх үүсвэрээр, сая м<sup>3</sup>



Манай улсын хувьд сүүлийн 3 жилд газар доорх усны олборлолт нэмэгдэж (3.4-3.5%), харин гадаргын усны олборлолт буурсан (9.6-0.1%) хандлагатай байна.

Усны биет хэмжээгээрх ашиглалтын хүснэгтийн усны нийт олборлолт нь Усны газрын “Ус ашиглалтын баланс”-ын нийт олборлолтын дүнгээс их буюу тэнцүү байна. Учир нь “Ус ашиглалтын баланс-д усан цахилгаан станцын хоолойгоор дамжуулан эрчим хүч үйлдвэрлэхэд ашигласан ус, уурхайн шавхсан усыг олборлосон гэж үзэж бүртгэдэггүй.

### Усны олборлолт, эдийн засгийн салбараар

Нийт олборлосон усыг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл, 2021 онд цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлийн салбарт 738.8 (57.2%) сая м<sup>3</sup>, хөдөө аж ахуйн салбарт 339.1 (26.1%) сая м<sup>3</sup>, уул уурхай, олборлох салбарт 109.9 (8.5%) сая м<sup>3</sup>, ус хуримтлуулах, ариутгах түгээх үйл ажиллагааны салбарт 77.2 (6.0%) сая м<sup>3</sup>, өрхийн эцсийн хэрэглээнд 11.2 (0.9%) сая м<sup>3</sup>, бусад салбарт 6.9 (0.5%) сая м<sup>3</sup>, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 6.4 (0.5%) сая м<sup>3</sup>, барилгын салбарт 2.9 (0.2%) сая м<sup>3</sup> усыг тус тус олборлосон байна.

Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлийн салбарт олборлосон 738.8 сая м<sup>3</sup> усны 697.6 сая м<sup>3</sup> ус нь усан цахилгаан станцд гадаргын уснаас олборлосон бол хөдөө аж ахуйн салбарт олборлосон 339.1 сая м<sup>3</sup> усны 106.9 сая м<sup>3</sup> усыг газар доорх усны эх үүсвэрээс олборложээ.

ХҮСНЭГТ 3. УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, салбараар, усны нөөцийн төрлөөр, 2021 он

Салбарууд	Газар доорх ус	Гадаргын ус	Нийт	Дүнд эзлэх хувь
	сая м <sup>3</sup>			хувь
<b>Нийт</b>	<b>362.7</b>	<b>929.7</b>	<b>1 292.4</b>	<b>100.0</b>
Хөдөө аж ахуй	106.9	232.1	339.1	26.2
Уул уурхай, олборлох	109.9	-	109.9	8.5
Боловсруулах үйлдвэрлэл	6.4	-	6.4	0.5
Барилга	2.9	-	2.9	0.2
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	41.3	697.6	738.8	57.2
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	77.2	-	77.2	6.0
Бусад	6.9	-	6.9	0.5
Өрх	11.2	-	11.2	0.9


### Усны олборлолт, зориулалтаар

Усны нийт олборлолтыг зориулалтаар нь авч үзвэл 2021 онд хамгийн их буюу 697.6 (54.0%) сая м<sup>3</sup> УЦС-д, 339.1 (26.2%) сая м<sup>3</sup> усыг ХАА-н усжуулалтад, 109.9 (8.5%) сая м<sup>3</sup> усыг уурхайд, 88.4 (6.8%) сая м<sup>3</sup> усыг унд ахуйд, 41.3 (3.2%) сая м<sup>3</sup> усыг хөргөлтөд, 16.1 (1.2%) сая м<sup>3</sup> усыг бусад зориулалтаар ашиглахаар олборлосон байна.

#### ХҮСНЭГТ 4. УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, зориулалтаар

	2019	2020	2021	<u>2021</u> 2020
	сая м <sup>3</sup>			хувь
<b>Нийт</b>	<b>1 368.5</b>	<b>1 281.7</b>	<b>1 292.4</b>	<b>100.8</b>
Усан цахилгаан станц	790.0	690.7	697.6	101.0
Усжуулалтын ус	351.6	352.9	339.1	96.1
Уурхайн ус	96.7	92.8	109.9	118.4
Хөргөлтийн ус	31.4	40.7	41.3	101.5
Бусад	13.3	18.9	16.1	85.4
Унд, ахуйд хэрэглэх ус	85.5	85.8	88.4	103.1

#### ЗУРАГ 6 . УСНЫ НИЙТ ОЛБОРЛОЛТ, дүнд эзлэх хувь, ашиглалтын төрлөөр



### УСНЫ НИЙТ АШИГЛАЛТ

Усны БНАХ-ийн дагуу усны нөөцөөс олборлосон усны хэмжээ болон эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан ус ашиглалтын нийлбэрээр усны нийт ашиглалт гарна.

Улсын хэмжээнд 2021 онд нийт 1425.6 сая м<sup>3</sup> ус ашигласны 1292.4 (90.7%) сая м<sup>3</sup> усыг эдийн засгийн салбарууд өөрсдийн хэрэглээнд олборлож, 133.2 (9.3%) сая м<sup>3</sup> усыг эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад усны нийт ашиглалт 14.6 сая м<sup>3</sup> буюу 1.0 хувиар өсжээ.

#### ХҮСНЭГТ 5. УСНЫ НИЙТ АШИГЛАЛТ, салбараар, 2021 он

Салбарууд	Нийт усны ашиглалт	Нийт олборлолт	Эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан ус
	сая м <sup>3</sup>		
<b>Нийт</b>	<b>1 425.6</b>	<b>1 292.4</b>	<b>133.2</b>
Хөдөө аж ахуй	339.1	339.1	-
Уул уурхай, олборлох	109.9	109.9	-
Боловсруулах үйлдвэрлэл	10.4	6.4	4.0
Барилга	3.3	2.9	0.4
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	741.1	738.8	2.2
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	77.3	77.2	0.1
Сувагжилтын систем	56.2	-	56.2
Бусад	16.8	6.9	9.9
Өрх	71.5	11.2	60.3

Эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан усны ашиглалт гэдэг нь ус хуримтлуулах, ариутгах, түгээх салбар (ЭЗҮАСА 36)-аас эдийн засгийн салбар, өрхөд төвлөрсөн ус хангамжийн систем, ус түгээх байр болон зөөврөөр дамжуулан түгээсэн цэвэр ус болон сувагжилтын систем (ЭЗҮАСА 37)-д цугларсан/татан зайлуулсан бохир усны нийлбэртэй тэнцүү байна. Иймд 2021 оны нийт эдийн засгийн бусад нэгжээс хүлээн авсан усны ашиглалт болох 133.2 сая м<sup>3</sup> усны 56.0 сая м<sup>3</sup> ус нь эдийн засгийн салбаруудаас татан зайлуулсан бохир ус бөгөөд үлдсэн 77.2 сая м<sup>3</sup> ус нь эдийн засгийн салбарууд, өрхөд түгээсэн цэвэр усны хэмжээ гэж ойлгоно.

#### ХҮСНЭГТ 6. УСНЫ НИЙТ АШИГЛАЛТ, салбараар

Салбарууд	2019	2020	2021	<u>2021</u> 2020
	сая м <sup>3</sup>			хувь
<b>Нийт</b>	<b>1 497.2</b>	<b>1 411.0</b>	<b>1 425.6</b>	<b>101.0</b>
Хөдөө аж ахуй	351.6	352.9	339.1	96.1
Уул уурхай, олборлох	96.7	92.8	109.9	118.4
Боловсруулах үйлдвэрлэл	8.2	9.1	10.4	114.2
Барилга	1.7	5.0	3.3	66.0
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	822.9	732.8	741.1	101.1
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	74.7	74.8	77.3	103.3
Сувагжилтын систем	54.4	54.7	56.2	102.7
Бусад	18.5	18.0	16.8	93.1
Өрх	68.5	70.8	71.5	101.0

#### 2.1.2. БИЕТ ХЭМЖЭЭГЭЭРХ НӨӨЦИЙН ХҮСНЭГТ

##### УСНЫ НИЙТ НӨӨЦ/ НИЙЛҮҮЛЭЛТ

Усны БНАХ-ийн дагуу усны нийт нөөц нь эдийн засгийн бусад нэгжид нийлүүлсэн ус болон эдийн засгаас байгальд хаях усны нийт буцалтын нийлбэртэй тэнцүү байна.

Улсын хэмжээнд 2021 онд нийт 971.2 сая м<sup>3</sup> ус нийлүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 7.3 (0.8%) сая м<sup>3</sup>-ээр өсжээ. Нийт усны нийлүүлэлтийг салбарын ангиллаар авч үзвэл, 2021 онд цахилгаан хий, дулаан үйлдвэрлэлийн салбараас 717.9 сая м<sup>3</sup>, ус хуримтлуулах, ариутгах, түгээх салбараас 77.3 сая м<sup>3</sup>, сувагжилтын системээс 56.1 сая м<sup>3</sup>, өрхөөс 55.5 сая м<sup>3</sup>, уул уурхай, олборлох салбараас 44.9 сая м<sup>3</sup>, боловсруулах салбараас 5.4 сая м<sup>3</sup> усыг тус тус нийлүүлсэн байна.

#### ХҮСНЭГТ 7. УСНЫ НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ, салбараар, 2021 он

Салбарууд	Нийт нийлүүлэлт	Эдийн засгийн бусад нэгжид нийлүүлсэн ус	Нийт буцалт
	сая м <sup>3</sup>		
<b>Нийт</b>	<b>971.2</b>	<b>133.2</b>	<b>838.0</b>
Хөдөө аж ахуй	3.1	-	3.1
Уул уурхай, олборлох	44.9	-	44.8
Боловсруулах үйлдвэрлэл	5.4	2.1	3.3
Барилга	1.0	0.2	0.8
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	717.9	0.2	717.6
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	77.3	77.3	-
Сувагжилтын систем	56.1	0.1	56.0
Бусад	10.0	6.0	4.1
Өрх	55.5	47.3	8.2


2021 онд нийт 971.2 сая м<sup>3</sup> ус нийлүүлсний 838.0 (86.3%) сая м<sup>3</sup> усыг эдийн засгийн салбарууд, өрхөөс байгальд хаяж, харин 133.2 (13.7%) сая м<sup>3</sup> усыг эдийн засгийн бусад нэгжид нийлүүлжээ.

#### ХҮСНЭГТ 8. УСНЫ НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ, салбараар

Салбарууд	2019	2020	2021	<u>2021</u> 2020
	сая м <sup>3</sup>			хувь
<b>Нийт</b>	<b>1045.9</b>	<b>963.9</b>	<b>971.2</b>	<b>100.8</b>
Хөдөө аж ахуй	3.2	3.3	3.1	93.9
Уул уурхай, олборлох	41.4	48.5	44.9	92.5
Боловсруулах үйлдвэрлэл	4.4	5.0	5.4	108.7
Барилга	0.7	1.3	1.0	76.8
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	806.7	710.9	717.9	101.0
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	74.7	74.8	77.3	103.3
Сувагжилтын систем	54.3	54.7	56.1	102.7
Бусад	10.8	11.0	10.0	91.1
Өрх	49.7	54.4	55.5	102.0

Байгальд хаяж буй усыг ашигласан зориулалтаар нь авч үзвэл, 2021 онд хамгийн их буюу усан цахилгаан станцын ус 697.6 (83.2%) сая м<sup>3</sup>, сувагжилтын системээс цэвэршүүсэн хаягдал ус 50.5 (6.0%) сая м<sup>3</sup>, уурхайн ус 40.5 (4.8%) сая м<sup>3</sup>, хөргөлтийн ус 18.1 (2.2%) сая м<sup>3</sup>, усны алдагдал 13.8 (1.6%) сая м<sup>3</sup>, бусад ус 17.5 (2.1%) сая м<sup>3</sup> байна.

#### ЗУРАГ 7. УСНЫ НИЙТ БУЦАЛТ, усны ашигласан зориулалтаар, дүнд эзлэх хувь



#### УСНЫ ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭ

Усны эцсийн хэрэглээ гэдэгт байгалиас буцааж нийлүүлэхгүйгээр авч ашигласан усыг хэлнэ. Усны эцсийн хэрэглээнд усны ууршилт, усны ширгэлт, бүтээгдэхүүнд шингэсэн ус, хэрэглээ орох бөгөөд дараах байдлаар тооцно.

$$\text{Усны нийт ашиглалт} = \text{Усны нийт нөөц} + \text{Усны эцсийн хэрэглээ}$$

Улсын хэмжээнд 2021 онд нийт 454.4 сая м<sup>3</sup> усыг хэрэглэсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 7.3 (1.6%) сая м<sup>3</sup>-ээр өсжээ.


#### ХҮСНЭГТ 9. УСНЫ НИЙТ ХЭРЭГЛЭЭ, салбараар

Салбарууд	2019	2020	2021	<u>2021</u> 2020
	сая м <sup>3</sup>			хувь
<b>Нийт</b>	<b>451.3</b>	<b>447.1</b>	<b>454.4</b>	<b>101.6</b>
Хөдөө аж ахуй	348.4	349.6	336.0	96.1
Уул уурхай, олборлох	55.3	44.3	65.1	146.9
Боловсруулах үйлдвэрлэл	3.8	4.1	5.0	121.0
Барилга	1.0	3.7	2.3	62.2
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэл	16.1	21.9	23.2	105.9
Ус хуримтлуулах, ариутгах түгээх	0.0	0.0	0.0	100.3
Сувагжилтын систем	0.1	0.1	0.1	110.7
Бусад	7.7	7.0	6.7	96.1
Өрх	18.8	16.4	16.0	97.7

Усны эцсийн хэрэглээг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарт 336.0 сая м<sup>3</sup>, уул уурхай, олборлох салбарт 65.1 сая м<sup>3</sup>, цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлд 23.2 сая м<sup>3</sup>, өрхөд 16.0 сая м<sup>3</sup>, бусад салбарт 6.7 сая м<sup>3</sup>, боловсруулах үйлдвэрлэлд 5.0 сая м<sup>3</sup>, барилгын салбарт 2.3 сая м<sup>3</sup>, сувагжилтын системд 0.1 сая м<sup>3</sup> усыг хэрэглэсэн байна.

*Усны нийт ашиглалт = Усны нийт нөөц + Усны эцсийн хэрэглээ* тодорхойлолтын дагуу усны нийт эцсийн хэрэглээг салбарын ангиллаар авч үзэхэд хөдөө аж ахуйн салбар хамгийн их буюу нийт ашиглалтынхаа 99.1%, барилгын салбар 69.6%, уул уурхайн салбар 59.2%, боловсруулах салбар 47.9%, үйлчилгээний салбарт 40.1%, өрх 22.4%-ийг байгальд буцаан хаяхгүйгээр хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл усны ууршилт, бүтээгдэхүүнд шингэсэн ус, ундны ус хэлбэрээр эдгээр салбар, өрх хэрэглээндээ ашигласан байна.

ЗУРАГ 8. УСНЫ ЭЦСИЙН ХЭРЭГЛЭЭ, НИЙТ АШИГЛАЛТЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, САЛБАРААР, 2021 он



## 2.2. УСНЫ БИЕТ УРСГАЛЫН ДАНСНААС ГАРАХ ТХЗ-ЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ТХЗ 6.3: 2030 он гэхэд дэлхийн түвшинд бохирдлыг бууруулах, хог хаях ажиллагааг халах, аюултай химийн бодис, материалыг гаргах явдлыг хамгийн бага түвшинд хүргэх, цэвэрлэгдээгүй бохир ус хувь хэмжээг хоёр дахин бууруулах, усыг дахин боловсруулж, цэвэршүүлэн хэрэглэх явдлыг [x] хувиар нэмэгдүүлэх замаар усны чанарыг сайжруулах

ТХЗ 6.4: 2030 он гэхэд бүх салбарт усны хэрэглээний үр ашгийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, усны хомсдолоос гаргах үүднээс цэвэр усны тогтвортой олборлолт, хангамжийг хангаж, усны хомсдолоос өртсөн хүн амын тоог үлэмж хэмжээгээр бууруулах

### ТХЗ 6.3.1: Цэвэрлэх байгууламжаар дамжуулан цэвэрлэсэн усны эзлэх хувь

Улсын хэмжээнд 2021 онд хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжид нийт 56.0 сая м<sup>3</sup> ус цугласны 50.5 сая м<sup>3</sup> ус буюу 90.1 хувийг цэвэрлэн, гадаргын усны нөөцөд хаясан байна.

